



**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn,
Цахим хуудас: www.mddc.gov.mn


2023.05.28 № 01/1128
танай _____-ны № _____-т

Хяналт шалгалтын ажлын дүгнэлт
зөвлөмж хүргүүлэх тухай

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу “Радио телевизийн үндэсний сүлжээ” улсын төсөвт үйлдвэрийн газарт төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж дүгнэлт, зөвлөмж гарсныг үүгээр хүргүүлж байна.

Зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллаж, 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор хэрэгжилтийн талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

Хавсралт .16 хуудастай.



Н.УЧРАЛ

1523003534

**“РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2022 ОН, 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
БАЙДЛААР ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2023.05.12

№

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт шалгалтын
зорилго**

Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд заасан яам болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж үнэлэх, дүгнэх арга хэмжээний хүрээнд “Радио телевизийн үндэсний сүлжээ” улсын төсөвт үйлдвэрийн газарт хяналт шалгалт хийж, дүгнэлт, зөвлөмж өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/34 дугаар тушаалаар байгуулж, удирдамжийг баталсан.

Уг хяналт шалгалтын зорилго нь “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2022 он, 2023 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагаанд хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, цаашид үүсэж болзошгүй аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оршино.

Хяналт-шалгалтыг хийхдээ Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгосон болно.

Ажлын хэсгийн удирдамжийн хүрээнд тус газрын байранд 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр байрлаж, газрын үйл ажиллагаа, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 2022 онд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хүний нөөцийн чиглэлээр 2022-2023 онд гаргасан захирлын тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэл, баримт бичгийн боловсруулалт, албан хэрэг хөтлөлт, архивын баримт бичгийн хадгалалт хамгаалалттай танилцлаа.

**Хоёр.Хяналт шалгалтын ажлын зохион
байгуулалт**

Ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Х.Сүрэнхорол ахалж, ажлын хэсгийн гишүүнээр Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Г.Болорчимэг, Шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтсийн мэргэжилтэн А.Анужин, Төрийн захиргааны удирдлагын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Г.Батбилэг, Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Д.Мөнхсарнай, ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн А.Түвшинзаяа нар ажиллалаа.

Хяналт шалгалтыг байгууллагын баримт бичгийг хянан үзэх, хяналт шалгалтын явцын үр дүнг зургаар баримтжуулах, тайлбар, мэдээлэл судалгаа, холбогдох баримт бичгийг гаргуулан авах, хуульд заасан бусад арга хэлбэрээр тухайн газарт хянаж үлдэх баримт болон тодруулах асуудлыг цахим хэлбэрээр хүлээн авч хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан болно.

Гурав.Хяналт, шалгалтын талаар /илэрсэн зөрчил/

1. Бодлогын чиглэлээр:

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь Радио долгионы тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг. Үүнд:

- Телевизийн дамжуулах сүлжээгээр 360 сум, суурин газарт 16 суваг,
- Их хүчний радиогийн дамжуулах сүлжээгээр улс, орон даяар Олон нийтийн радиогийн 1, 2 суваг,
- Хэт богино долгионы радио дамжуулах станцаар аймгийн төв болон Улаанбаатар хотод Олон нийтийн радиогийн 1, 2, 3 суваг,
- Улаанбаатар хотын радио шугамаар Олон нийтийн радиогийн 1, 2, 3 сувгуудыг тус тус дамжуулан хүргэдэг байна.

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад үүссэн гэмтэл саатлын байдлыг дурдвал:

- 2022 онд Телевизийн 18 сувгуудыг 39,945,600 суваг/цаг дамжуулах ёстойгоос 39,848,728 суваг/цаг буюу 99.8% дамжуулалт хийж, 96,872 суваг/цагийн гэмтэл, саатал;

- Их хүчний радио станцаар радио өргөн нэвтрүүлгийг 278,495 суваг/цаг дамжуулах ёстойгоос 276,636 суваг/цаг буюу 99.3% дамжуулалт хийж, 1,859 суваг/цагийн гэмтэл, саатал;

- FM хэт богино долгионы 35-н радио станцаар радио өргөн нэвтрүүлгийг 215,715 суваг/цаг дамжуулах ёстойгоос 214,052 суваг/цаг буюу 99.2% дамжуулалт хийж, 1,664 суваг/цагийн гэмтэл, саатал;

- Улаанбаатар хотын шугамын радиогийн дамжуулах станцаар радио өргөн нэвтрүүлгийг 352 983 835 цэг/цаг дамжуулах ёстойгоос 352 262 055 цэг/цаг буюу 99.8% дамжуулалт хийж, 721 780 цэг/цаг гэмтэл, саатал тус тус гарсан байна.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь дараах 9 төрлийн тусгай зөвшөөрөл олгон ажилладаг. Үүнд:

1.Радио телевизийн газрын сүлжээ үйлчилгээ эрхлэх/№16800001/ тусгай зөвшөөрөл;

2.Нийтийн хэрэгцээнд урт, дунд долгионоор радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх /№006/BS01/ радио дамтамж ашиглах тусгай зөвшөөрөл;

3.Нийтийн хэрэгцээнд богино долгионоор радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх/№007/BS02/ радио дамтамж ашиглах тусгай зөвшөөрөл;

4.Нийтийн хэрэгцээнд богино долгионоор радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх/№090/BS03/ радио дамтамж ашиглах тусгай зөвшөөрөл;

5.Нийтийн хэрэгцээнд хэт богино долгион/ФМ105.5/-оор радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх/№22800168/ радио дамтамж ашиглах тусгай зөвшөөрөл;

6.Нийтийн хэрэгцээнд хэт богино долгион/ФМ100.9, 103.1, 106/-оор радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх/№22800044/ радио дамтамж ашиглах тусгай зөвшөөрөл;

7.Нийтийн хэрэгцээнд тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх/№361/DTV192/ радио дамтамж ашиглах тусгай зөвшөөрөл;

8.Нийтийн хэрэгцээнд хэт богино долгион/ФМ107, 103.0, 106.7/-оор радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх/№22800046/ радио дамтамж ашиглах тусгай зөвшөөрөл;

9.Нийтийн хэрэгцээнд хэт богино долгион/ФМ105.5/-оор тоон радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх/№22820002/ радио дамтамж ашиглах тусгай зөвшөөрөл.

Дээр дурдсан тусгай зөвшөөрлийн хүрээнд:

- радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ
- телевизийн дахин дамжуулах үйлчилгээ
- байр талбай, цамхаг түрээслэх үйлчилгээ
- орчуулгын төхөөрөмж, зөөврийн өсгөгч түрээсийн үйлчилгээ гэсэн нийт 4 төрлийн үйлчилгээтэй бөгөөд үүнээс байр талбай, цамхаг түрээслэх үйлчилгээ болон орчуулгын төхөөрөмж, зөөврийн өсгөгч түрээсийн үйлчилгээний үнэ тариф байгууллагын вебсайтад ил тод нийтлэгдсэн байна.

Улаанбаатар хотод тоон телевизийн 14 дамжуулах станц шилэн кабель, хиймэл дагуулын холбоогоор дамжуулалт хийж байгаа бөгөөд үүнээс 7 станц RF, коаксаль кабель болон линкээр дамжуулан нөөцийн горимд ажиллах боломжтой байна. Орон нутагт Дархан, Орхон болон 18 аймгийн төвүүд, 326 сум суурин газруудад тоон телевизийн станц хиймэл дагуулын сүлжээгээр дамжуулалт хийж байгаа бөгөөд нөөц ажиллах боломжгүй байна. Станцуудын цахилгааны эх үүсвэрийн хувьд Улаанбаатар хотод 10 станц нөөц тэжээлтэй, орон нутагт одоогоор нөөц тэжээлийн үүсвэртэй станц байхгүй байна. Телевизийн өргөн нэвтрүүлгийн хувьд DVBT-2 стандартаар дохио дамжуулалтын үндсэн шалгуур болох C/N, MER, урсгалын хурд, дууны түвшин зэрэг үзүүлэлтүүд хэвийн хэмжээнд ажиллаж байна.

Их хүчний радио станцын хувьд УБ хотод 5 станцаас 4, орон нутагт Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Баян-Өлгий, Хөвсгөл аймгийн төвүүд болон томоохон сум суурин газруудад байрлах 42 FM станцууд интернэт, шилэн кабель, хиймэл дагуул ашиглан нөөцийн горимд ажиллах боломжтой байна. Тэжээлийн нөөц эх үүсвэрийн хувьд Улаанбаатар хот болон орон нутаг дахь станцууд бүгд нөөцтэй байна.

Өргөн нэвтрүүлгийг дамжуулах техник, тоног төхөөрөмжийн нөөцийн хувьд телевизийн станцын нэвтрүүлэгч 5ш, хүлээн авагч болон модулятор тус бүр 2ш бэлэн байгаа бөгөөд нийт 11 төхөөрөмжийг нөөц бүрдүүлэхээр захиалаад байна. FM станцад нөөцөд төхөөрөмжгүй байгаа тул 6ш нэвтрүүлэгч захиалсан байна.

Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах чиглэлийн 6.8, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн “4.1.5.5 Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ байгуулна” гэж заасан арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэхэд хяналт шалгалтын ажил хийхэд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/76 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсэг “Хонхорын аналогийн радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах станцыг тоон технологид шилжүүлэх” техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулснаас хойш тодорхой ахиц дэвшил гараагүй буюу төлөвлөгөөний биелэлт 30 хувьтай, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн зардал улсын төсөвт суухгүй байгаагаас шалтгаалан хэрэгжилтийн явц удаашралтай байна.

Тус ажлын хүрээнд 2022 онд “Радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг тоон технологид шилжүүлэх техник эдийн засгийн үндэслэл”-г Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монголын Үндэсний Олон нийтийн радио телевиз болон “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын хамтран шинэчилсэн байна. 2023 онд радио өргөн нэвтрүүлгийн DAB+-н технологийг Улаанбаатар хотод шинээр нэвтрүүлэхийн тулд давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг шинээр авсан. Мөн Цахим үндэстэн бодлогын баримт бичгийн нэгдүгээр зорилт дахь “Өргөн нэвтрүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэсэн хэсгийн 1.2.6-д заасан арга хэмжээний хүрээнд Чингэлтэй дүүргийн тоон телевизийн 200Вт-ын станцын чадлыг нэмэгдүүлж нөөц 500Вт чадлын станцаар, Хан-Уул дүүргийн Нисэх орчмын 100Вт-ын чадлын станцын чадлын нэмэгдүүлж 200Вт чадлын станцаар тус тус сольж ажилласан байна.

Саатал гэмтэл, үйлчилгээ тасалдсан хугацаа, гэмтлийг тогтоосон хугацаанд засварласан байдалд илэрсэн зөрчил:

1. Телевизийн дамжуулах сүлжээний саатлын 50% нь эрчим хүчний саатал, 20% нь тоног төхөөрөмжийн гэмтэл, радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ, FM-н дамжуулах сүлжээний 39%-ийг эрчим хүчний гэмтэл, 36%-ийг тоног төхөөрөмжийн гэмтэл эзэлсэн байна. Жил бүр хамгийн их гардаг гэмтэл, саатлыг эзэлдэг эрчим хүч, тоног төхөөрөмжийн саатлыг багасгах талаар төлөвлөгөөтэй арга хэмжээ аваагүй;

2. Орон нутагт дамжуулах станцын нөөц тоног төхөөрөмж байхгүй, Оросын Холбооны Улс сэлбэг үйлдвэрлэхээ зогсоосноос үүдэж ламп, сэлбэг зэргийг гэмтэл саатал гарахад шууд сэлбэж тавих боломжгүй гэх нөхцөл байдлаас үүдэлтэй гэмтлийг засварлах хугацаа хэтэрдэг;

3. Орон нутагт гарсан гэмтэл саатлын мэдээг утсаар өгч, excel дээр бүртгэл хийдэг нь түргэн шуурхай, үнэн бодит мэдээ авах, баталгаажуулах, дүгнэлт, анализ хийх боломжгүй;

4. Байгаль цаг агаарын нөлөөнөөс хамааралтай нэвтрүүлгийн чанар муу, шуугьдаг;

5. Аналоги станцын урт долгионы хүлээн авагч байхгүйн улмаас сонсогчийн тоо буурснаас үүдэлтэй бүрэн хүчин чадлаараа ажиллаж чаддаггүй;

6. Дамжуулах станцуудын гэмтэл, саатлаас урьдчилсан сэргийлэх үзлэг шалгалт хийгддэггүй гэх зэрэг зөрчлүүд илэрсэн.

Харилцаа холбооны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд илэрсэн зөрчил:

Төрийн өмчийн хорооны 2015 оны 230 дугаар тогтоолын хавсралтаар “Радио, телевизийн сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийг шинэчлэн баталсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм батлах талаар тусгаагүй бөгөөд тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-д “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах бүрэн эрхтэй” гэж заасан байна.

Харилцаа холбооны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “Радио, телевизийн сүлжээг радио, телевизийн нэвтрүүлгийн хөтөлбөр бэлтгэх байгууллага үйлчлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ашиглана.” гэж заасны дагуу дамжуулж буй бүх радио, телевизүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр хөтөлбөр дамжуулах үүрэгтэй боловч нийт үйлчилгээ эрхлэгчидтэй гэрээг байгуулж дуусаагүй байна.

Жишээлбэл: FM дамжуулах станцаар дамжуулж буй радио нэвтрүүлгийн хөтөлбөр бэлтгэх байгууллагатай байгуулсан гэрээ /ХХТХ 19.2 /-г дурдаж болно.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь одоогоор өргөн нэвтрүүлгийн 8 телевиз, орон нутгийн 4 телевиз болон радиогийн 1, 2 дугаар сувгуудтай гэрээ байгуулсан боловч өргөн нэвтрүүлгийн 8 телевизтэй гэрээг байгуулаагүй байна.

Байгууллагын цахим хаягт тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж буй радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, телевизийн дахин дамжуулах үйлчилгээ гэх 2 төрлийн үйлчилгээний үнэ тариф болон жишиг гэрээний загварыг одоогоор нээлттэй байршуулаагүй байна.

Радио, телевизийн газрын дахин дамжуулах сүлжээг хөгжүүлэх бодлого буюу дэд бүтэц хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдаар батлуулаагүй байна.

2. Хүний нөөцийн чиглэлээр:

Хүний нөөцтэй холбоотой Б тушаал 2022 онд 117, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 46, үйл ажиллагаатай холбоотой гарсан А тушаал 2022 онд 28, 2023 оны 1

дүгээр улирлын байдлаар 18 тушаал бүртгэгдэж, байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг дараах тушаалуудаар баталсан байна. Үүнд:

- Захирлын 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн “Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай” А/06 дугаар тушаал;

- Захирлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Радио телевизийн газрын сүлжээний үйлчилгээний талаар өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх журам батлах тухай” А/26 дугаар тушаал;

- Захирлын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Албан хаагчдын “Ёс зүйн дүрэм батлах тухай” А/12 дугаар тушаал;

- Захирлын 2023 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн “Дотоод албан томилолтын журам шинэчлэн батлах тухай” А/13 тушаал

- Захирлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссын ажиллах журам батлах тухай” А/18 дугаар тушаал тус тус батлагдсан байна.

Хүний нөөцийн чиглэлээр 2022-2023 онд гаргасан тушаал шийдвэртэй холбоотой илэрсэн зөрчил:

Хууль, журмын хэрэглээтэй холбоотой гарсан зөрчлүүд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.1-д “Байгууллага нь үндсэн үйл ажиллагааны болон хүний нөөцийн чиглэлээр тус тусад нь тушаал, захирамж гаргана”, 3.2.1.2-т “Хүний нөөцийн чиглэлээр”:

“-ажилд томилох, чөлөөлөх;

-өөр ажилд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах;

-гэрээгээр ажиллуулах;

-мэргэшлийн зэрэг, дэв, цол, түүний нэмэгдэл олгох;

-ажилтны ур чадварыг тогтоох, нэмэгдэл олгох;

-ээлжийн амралтын хуваарь батлах, амралт олгох;

-сахилгын шийтгэл ногдуулах;

-төрийн шагнал, салбарын дээд шагналаас бусад шагналаар шагнах;

-тэтгэмж олгох, туслалцаа үзүүлэх;

-хувийн зардлаар сургалтад хамруулахаар” гэж заасныг мөрдөөгүй.

Тухайлбал: Хүний нөөцийн чиглэлээр “Б”-ээр дугаарлах тушаалуудыг “А”-аар дугаарлаж, тушаалын хавсралтыг баримт бичгийн стандарт /MNS5140-1:2021/-ын дагуу зөв үйлдээгүй дараах зөрчилтэй тушаалууд байна. Үүнд:

-“Ээлжийн амралтын хуваарь батлах тухай” 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/01 дүгээр,

-“Ээлжийн амралтын хуваарь батлах тухай” 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/01 дүгээр,

-“Ур чадварын нэмэгдэл, цалингийн урамшуулал олгох тухай” 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/03 дугаар,

-“Ажилласан жилийн нэмэгдэл олгох тухай” 2022 оны А/07, А/13, А/21, А/23 дугаар тушаалууд.

2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.4.4-т “байгууллага, түүний бүтцийн нэгжийн болон албан тушаалтны албан тушаалын нэрийг товчлохгүй бүтэн бичих” гэж заасныг зөрчсөн.

Тухайлбал: Тус газрын захирлын 2022 оны “Хариуцлагатай жижүүр томилох тухай” А/22, А/28 дугаар, 2023 оны А/09 дүгээр тушаалуудад товчлол хэрэглэсэн байна.

3. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.3-т “Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол үндэслэл хэсэгт уг баримт бичгийг зохион бүрдүүлэх хууль зүйн үндэслэл, шалтгаан, зориулалт, зорилгыг тодорхой бичнэ” гэснийг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалтад “эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах” гэснийг тус тус мөрдөөгүй зөрчил илэрлээ.

Тухайлбал: Зөвхөн “Радио, телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын дүрэм, Үйлдвэрчний эвлэлийн хороо хоорондын байгуулсан “Хамтын гэрээ”-г үндэслэхээр зааж, холбогдох бусад хууль, эрх зүйн зохицуулалтыг тусгаагүй тушаал шийдвэрүүд гаргасан. Жишээлбэл:

-“Хяналтын хугацаа батлах тухай” 2022 оны А/10 дугаар,

-“Төсөв батлах тухай” 2022 оны А/16 дугаар,

-“Хөрөнгө гаргах тухай” 2022 оны А/20 дугаар,

-“Ёс зүйн дүрэм батлах тухай” 2023 оны А/12 дугаар тушаалууд байна.

-2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тухай” А/24 дүгээр тушаалын үндэслэл хэсэгт Шилэн дансны тухай хуулийн ямар зүйл, заалтыг үндэслэж байгаа нь тодорхойгүй, зөвхөн хуулийн нэр бичсэн;

-“Ажлын цагт өөрчлөлт оруулах тухай” 2022 оны 12 дугаар сарын 01-ний А/25 дугаар тушаалын үндэслэл хэсэгт Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг, 84 дүгээр зүйлийн 84.5 дахь хэсгийг, -“Цалинд өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/02 дугаар тушаалын үндэслэл хэсэгт Хөдөлмөрийн тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.3 дахь хэсгийг, “Үүрэг чиглэл өгөх тухай” 2023 оны А/04, А/07 дугаар тушаалын үндэслэл хэсэгт Хөдөлмөрийн тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.3 дахь хэсгийг, 2022 оны “О.Буянжаргалд чөлөө олгох тухай” Б/35 дугаар, “Ө.Батгэрэлд чөлөө олгох тухай” Б/36 дугаар, Б.Ариунзоригт чөлөө олгох тухай” Б/37 дугаар тушаалын үндэслэл хэсэгт Хөдөлмөрийн тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.1 дэх хэсгийг “заалт” гэж тус тус буруу хэрэглэсэн.

4. Тушаалд хууль, эрх зүйн үндэслэлийг оновчтой илэрхийлээгүй, зөв бичгийн болон утга агуулгын алдаатай, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын холбогдох заалтыг мөрдөөгүй хэд хэдэн төрлийн зөрчилтэй тушаал байна.

Тухайлбал: 2022 онд хүний нөөцийн чиглэлээр 117 тушаал батлагдсанаас 67 тушаалын үндэслэл хэсэгт албан хаагчаас гаргасан хүсэлтийг бичсэн. Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.3-т “Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол үндэслэл хэсэгт уг баримт бичгийг зохион бүрдүүлэх хууль зүйн үндэслэл, шалтгаан, зориулалт, зорилгыг тодорхой бичнэ.” гэж заасныг мөрдөөгүй байна.

-2022 оны “Ж.Ганхүүг ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай” Б/01 дүгээр тушаалд хүсэлтийг үндэслэл хэсэгт бичсэн. Ингэхдээ харьяалахын тийн ялгалын нөхцөлийг буруу залгасан;

-2022 оны “Н.Лхамсүрэнд хүүхэд асрах чөлөө олгох тухай” Б/09 дүгээр тушаалд мөн л ажилтны хүсэлтийг үндэслэсэн, тушаалын бичвэрийн дугаарлалт зөрсөн;

-2022 оны “Т.Бат-Эрдэнээр ажил хавсран гүйцэтгүүлэх тухай” Б/11 дүгээр тушаалд “Төмөртөгөө овогтой Бат-Эрдэнэ” гэх мэтээр тушаалд тухайн хүний эцэг (эх)-ийн нэрд харьяалахын тийн ялгалын нөхцөлийг залгаж бичих шаардлагыг биелүүлээгүй;

-2022 оны “Б.Содбаярыг үндсэн ажилтнаар томилох тухай” Б/14 дүгээр тушаалыг тамгагүй буюу хүчин төгөлдөр бус байхад архивын нэгж үүсгэсэн;

-2022 оны “Д.Болорсайханд сахилгын шийтгэл ногдуулах тухай” Б/55 дугаар тушаалд “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын дүрмийн 6.3.11-т “Үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлуулах” гэж хамааралгүй зохицуулалт үндэслэсэн;

-2022 оны “Сэр-Одын Отгонжаргалаар ажил хавсран гүйцэтгэх тухай” Б/45 дугаар тушаалын үндэслэх хэсэгт тус газар үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан “Хамтын гэрээ”-ний 3.6 буюу “тус газрын жилийн эцсийн үр дүнг тооцож жилийн ажлын үр дүнг харгалзан урамшуулал олгоно” гэсэн алдаатай зохицуулалт үндэслэсэн;

-2022 оны “С.Мягмарсүрэнгээр ажил хавсран гүйцэтгүүлэх тухай” Б/27 дугаар тушаалын үндэслэх хэсэгт Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1,2, 79 дүгээр зүйлийн 79.1,2 гэж хуулийн зүйл, хэсэгт бичиглэлийн алдаа гаргасан;

-2022 оны “О.Дуламсүрэнг ажилд томилох тухай” Б/68 дугаар тушаалд Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1, 60.1.3, 139.2 дахь хэсэг гэж хамааралгүй зохицуулалтыг үндэслэсэн, хуулийн үндэслэл бичвэрийн агуулга зөрүүтэй байна. Өөрөөр хэлбэл дээрх үндэслэхээр заасан зохицуулалтууд нь ажилтныг томилох бус буюу 60.1.3-т жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй; 139.2-т Хүүхэд асрах чөлөө нь дууссан, эсхүл дуусаагүй боловч ажилтан хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнийг ажлын байранд нь үргэлжлүүлэн ажиллуулах үүрэгтэй бөгөөд хэрэв орон тоо нь хасагдсан, ажилтны тоог цөөрүүлсэн бол адил чанарын өөр ажлын байранд ажиллуулах талаар заасан,

-2022 оны “Б.Жавхлантагсийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах тухай” А/61 дүгээр тушаалыг “Б”-ээр дугаарлаагүй, мөн тушаалын үндэслэх хэсэгт Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1,2 гэж хуулийн зүйл, хэсэгт бичиглэлийн алдаа гаргасан;

-2023 оны “Үүрэг чиглэл өгөх тухай” А/04, А/07 дугаар тушаалын тэргүү бичвэрийн агуулгатай нийцээгүй;

-Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсэгт “Ажил олгогч ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон тухай шийдвэртээ ажил хүлээлгэн өгөх хугацааг заана” гэж заасан бөгөөд тус газрын ажлаас чөлөөлөх, чиг үүрэг өөрчлөх агуулгатай тушаалуудад ажил хүлээлгэн өгөх хугацааг тусгаагүй. Жишээлбэл: Газрын даргын 2023 оны “Б.Золжаргалыг ажлаас чөлөөлөх тухай” Б/03 дугаар тушаал;

-2022 оны “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/08 дугаар тушаал Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэгт “Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байна” гэж заасныг зөрчсөн байна.

Ажилтны цалин хөлсийг тогтоохтой холбоотой зөрчлүүд:

“Радио, телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын бүтэц, орон тоо, цалингийн сүлжээг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 09-ний А/51 дүгээр тушаалаар баталсан. Мөн захирлын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Цалин нэмэгдүүлэх тухай” А/03 дугаар, 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн “Цалин нэмэгдүүлэх тухай” А/06 дугаар тушаалаар 2023 онд 2 удаа албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэн, албан хаагчдын цалинг харилцан адилгүй тогтоосон.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-д “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах бүрэн эрхтэй” гэж заасантай зөрчилдсөн..

3. Өргөдөл гомдлын чиглэлээр:

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-т Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд 2022 онд нийт 120 өргөдөл, 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 46 өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэсэн байна. 2022, 2023 онд бүртгэгдсэн өргөдөл

гомдол бүхэлдээ хүний нөөцийн чиглэлээр буюу ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх, тэтгэмж хүсэх, чөлөө авах, зэрэг дэвийн нэмэгдэл олгуулахаар хандсан өргөдөл гомдлууд байна.

Мөн тус газрын захирал 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/26 дугаар тушаалаар “Радио телевизийн газрын сүлжээний үйлчилгээний талаар өргөдөл, гомдол, санал хүсэлт, хүлээн авах, шийдвэрлэх журам”-ыг баталсан байна. Уг журамд гомдол саналыг хүлээн авах сувгуудын мэдээллийг тус газрын <https://rtbn.gov.mn/> цахим хуудаст байршуулж, мэдээллийн хэрэгслээр сурталчлан түгээж байна.

Иргэн хуулийн этгээдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлттэй холбоотой илэрсэн зөрчлүүд:

-2022, 2023 оны өргөдөл гомдлын дэвтрийн бүртгэл хөтлөлтөд хяналт шалгалт хийхэд бичиглэл, дугаарлалт буруу;

-Шийдвэрлэлтийн хариуг холбогдох хууль, журмын дагуу хэрхэн мэдэгдсэн талаарх тэмдэглэл хэт ерөнхий;

-Өргөдөл, гомдлыг хүлээн авч, хадгаламжийн нэгж үүсгээгүй /задгай/;

-Өмнөх оны бүртгэлийн дэвтрийг архивд хүлээлгэн өгөөгүй;

-Албан хаагчдын гаргасан хүсэлтийг ихэвчлэн тушаалаар болон биечлэн уулзаж, эсхүл утсаар шийдвэрлэдэг /хариу өгснийг нотлох баримтгүй/;

-Тус газрын <https://rtbn.gov.mn/> цахим хуудаст байршуулж, мэдээллийн хэрэгслээр хүлээн авч буй өргөдөл гомдлын бүртгэлийн талаарх мэдээлэл хангалтгүй;

-Өргөдөл гомдлын бүртгэлийн дэвтэрт “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай” хуулийн дагуу өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, шаардлагатай бол уг хугацааг 30 хүртэл хоногоор сунгах, саналын шинжтэй өргөдлийн хариуг 60 хоногт багтаан шийдвэрлэхээр заасан хугацааг баримталсан эсэх нь тодорхойгүй гэх мэт нийтлэг зөрчлүүд илэрсэн байна.

4. Яамнаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажилласан талаар:

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/06 дугаартай “Хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар тус байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн ажлын 10 хоногт хийж гүйцэтгэсэн.

Хяналт, шалгалтын ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмж бүхий тайланг бэлтгэн 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01/506 дугаартай албан бичгээр Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-т зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосон байна.

Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд илэрсэн зөрчил:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01/506 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийн талаар “Радио, телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Зөвлөмжийн биелэлтийн тухай” 01/86 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн.

“Тус газар нь шалгалтын мөрөөр ирүүлсэн зөвлөмжийн дагуу 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр газрын захирлын А/11 тушаалаар “Ажлын хэсэг” байгуулж, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа талаар холбогдох албан бичигт дурдсан боловч, 2022 оны А/11 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн тайлан, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар хүргүүлсэн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайланг ирүүлээгүй.

Дээрх хугацаанд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 09/896 дугаар албан бичгээр “Ажлын хэсгийн тушаал, төлөвлөгөөтэй танилцах”-ыг хүссэн боловч мөн л хариуг ирүүлээгүй.

Иймд 2023 оны хяналт шалгалтаар “Ажлын хэсэг байгуулах тухай” А/11 дүгээр тушаалын хэрэгжилттэй танилцсан ба одоогоор ажлын хэсгийн бүрэлдэхүүнд байсан 7 албан хаагч ажлаас гарсан буюу чөлөөлөгдсөн байна.

Хяналт шалгалтын явцад ажлын хэсгийн тайланг дараах байдлаар авлаа.

№	Өгсөн зөвлөмж	Хэрэгжилт	Үнэлгээ
1.	Газрын бүтэц зохион байгуулалтын албан тушаал, ажлын байранд чиг үүргийн шинжилгээ хийж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгах, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгон чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны оронд шинээр ажилтан авахгүй байхаар менежментийн өөрчлөлт хийх.	Хэрэгжилтийг ханган ажилласан байх ба Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргад хандан 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 01/82 дугаартай албан бичгээр тус газрын бүтэц орон тоо болон цалингийн жишгийн төслийг шийдвэрлүүлэхээр ирүүлсэн байна.	100
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичигт туссан арга хэмжээний биелэлтийг тухай бүр бүрэн гүйцэтгэлтэй тайлагнаж хэвших	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нэг арга хэмжээ туссан бөгөөд хэрэгжилтийн биелэлт 30 хувьтай байна.	30
3	Одоо байгаа орон тоонд телевизийн дамжуулах сүлжээний хамрах хүрээг нэмэгдүүлэх арга хэмжээг авах. Жишээ нь: Гэр хороолол, зуслангийн бүсийн хамрах хүрээний хаалттай орчинд нэмэлт тор тавих, шаардлагатай газруудад simulation хийж гаралтын чадлыг нэмэх гэх мэт.	Чингэлтэй ууланд байрлах 200Вт-н гаралтын чадалтай тоон телевизийн станцыг 500Вт-н станцаар, нисэхэд байрлах 100Вт-н чадалтай тоон телевизийн станцыг 200Вт-н нэвтрүүлэх станцаар тус тус сольж сүлжээний хамрах хүрээг нэмэгдүүлсэн байна.	90
4	Гамшгийн үеийн техникийн төлөвлөгөө боловсруулан сайдаар батлуулах	Радио телевизийн үндсэн сүлжээ УТҮГ-ын гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулан БГД-ийн онцгой байдлын хэлтсийн орлогч, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, ахмадаар батлуулсан байна.	100
5	Онц байдал болон гамшгийн үеийн мэдээг хэт богино долгионы радио станцуудаар дамжуулах /УБ хот болон орон нутаг/	Телевизийн төв станц УКВ дээр Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлагын зарлан мэдээлэх төвтэй холбогдох төхөөрөмжүүд байрлуулан холбоход бэлэн болсон байна.	90
6	Радио өргөн нэвтрүүлгийн найдвартай тасралтгүй арга хэмжээг авах	Хонхрын их хүчний радио станцыг радио линк, шилэн кабель болон хиймэл дагуулын сүлжээтэй холбосон, орон нутгийн 5 радио станцыг интернэт болон хиймэл дагуулын сүлжээгээр холбож тасалдалгүй, найдвартай ажиллагаагаар хангасан.	100
7	Радио болон телевизийн дахин дамжуулах станц эрчим хүчгүй үед ажиллах боломжийг бүрдүүлэх	Сайтуудын нөөц цахилгаан эх үүсвэрийг бүрдүүлэх тоног төхөөрөмжийн судалгаа хийж, шаардлагатай хөрөнгө оруулалтын санал боловсруулсан байна.	30
8	Дэлхийн улс орнуудын радио станцуудын программыг дамжуулдаг нэгдсэн флатформ болох Garden radio аппликейшнд холбогдох	Монгол Улсыг сурталчлан таниулах зорилгоор веб болон гар утас платформд суурилан үндэсний радиогийн контентийг дэлхий дахинд дамжуулах, дэлхийн улс орны	100

		25,000 гаруй радио станцуудыг нэгтгэсэн гар утасны аппликейшн болох Радио цэцэрлэг (Radio Garden) апп-нд холбогдох шаардлага бүхий 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03/29 тоот албан бичиг хүргүүлэн МҮОНРТ-н 1,2,3 сувгууд тус апп-нд холбогдсон.	
9	Garden radio веб сайтад Үндэсний олон нийтийн радиогийн 1, 2 болон P3 сувгуудыг бүртгүүлэн, Garden radio аппликейшнээр дээрх сувгуудыг сонсогч хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байна.	Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 3.3-т заасны дагуу МҮОНРТ-ын сувгийн сонсголын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор И-Монгол Академи УТҮГ-тэй уулзалт хийж 2022 оны 09 дүгээр сарын 10 нд 1-р сувгийн шууд эфирийг И-Монгол платформд холбосон.	100
10	DVB-T2 тоон телевизийн үйлчилгээ авч буй хэрэглэгчийн судалгааг хийж танилцуулах	Тоон телевиз, урт долгионы болон ФМ105.5-ын хэрэглэгчийн судалгааг 2021 оны эцсийн байдлаар боловсруулан 2022 оны 09,19-ны өдрийн 01/203 тоот албан бичгээр ЦХХХЯ-д хүргүүлсэн.	70
11	Инженер, техникийн ажилчдыг сайжруулах арга хэмжээ авах	Байгууллагын 2022-2023 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор нийт 31 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулж, албан хаагчдыг сургалтад бүрэн хамруулсан байна. Үүнээс цахим сургалт 30 удаа, танхимын сургалт 1 удаа тус тус зохион байгуулсан байна.	100
12	Салбарын яамнаас хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээг дэмжин ажиллах. Тухайлбал: орон нутагт ажиллаж буй инженер техникийн ажилчид, операторуудад яамнаас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, арга хэмжээг таниулах, эдгээр салбарын ажилчид, орон нутгийн иргэдэд яамны үйл ажиллагааг сурталчлан таниулах, мэдээ, мэдээллийг түгээн ажиллах.	Хэрэгжилт тодорхойгүй	0

5. Архив албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

1.1.данс бүртгэлийн тухай:

Тус байгууллагын Үндсэн хөмрөгийн архивын цаасан суурьтай баримт 2005-2022 он хүртэлх байнга хадгалах 260, түр хадгалах 820, 70 жил хадгалах 42 хадгаламжийн нэгжтэй, цомог 4, цомог дахь гэрэл зураг 65, CD 2, DVD 2 байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2-т “архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан бүрдүүлэх” гэж заасны дагуу үндсэн хөмрөгийн цахим хэлбэрээр буюу цахим тээгчид байнга хадгалах 104, түр хадгалах 20, 70 жил хадгалах 26, кино дуу, дүрсний баримт 2, гэрэл зургийн баримт 2, цомог 4 тус тус бүртгэлтэй байна.

1.2.нөхөн бүрдүүлэлт:

Тус байгууллага нь 2022 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг тус газрын захирал 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр баталсан байна. Тухайн онд байнга хадгалах 15, түр хадгалах 2, 70 жил хадгалах 65 хадгаламжийн нэгжтэй, цомог 1, цомог дахь гэрэл зураг 1, CD 1, DVD 1 тус тус бүртгэлтэй байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 25.1-д заасны дагуу тус газрын даргын 2015 “Байгууллагын баримт нягтлан шалгах комисс шинэчлэн томилох тухай”

95 дугаар тушаалаар баримт нягтлан шалгах комисс /цаашид БНШК гэх/ байгуулсан байна.

1.3.ашиглалт:

“Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 12.11, 12.19, 12.25-т заасны дагуу архивын баримтын ашиглалтын тоо бүртгэлийг хөтөлсөн эсэхийг 2022, 2023 оны баримтуудыг судалсан болно.

1.4.хадгалалт, хамгаалалт:

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5.5.2-т “архивыг зориулалтын байр, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах ...” гэж заасны дагуу Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ нь архивын зориулалтын байр, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хувьд цонхгүй 1 өрөөтэй, хаалганы баруун, зүүн талд галын хортой, лац болон лацны суурьтай, архивын баримтын 2 нягтаршуулсан, 1 төмөр шүүгээтэй, 1 галын дохиололтой, 1 хамгаалалтын бүрхүүл бүхий чийдэнтэй, 1 унтраалгатай, 1 төмөр хувин, 1 чийг, дулаан хэмжигчтэй байна. Галын 2 хорыг шалгаж хяналтын хуудаст тэмдэглэсэн. Чийг, дулааны хэмжээ тогтвортой байна.





Мөн Үндэсний төв архивын 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр олгосон Байгууллагын архивын гэрчилгээтэй.






Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 6.5.2-т заасны дагуу аврах гарцтай, аврах зам, гарцыг заасан тэмдгийг байрлуулсан. Мөн 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр “2023 оны архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөө”-г баталсан байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23.4-т “байгууллага архивын орон тооны ажилтантай байх бөгөөд ...”, 35.3-т “байгууллага орон тооны бичиг хэргийн ажилтантай байна” гэж тус тус заасны дагуу тухайн байгууллага нь Архивын ерөнхий газрын 6253, 19/014 дугаар бүхий мэргэжлийн үнэмлэхтэй Архив, бичиг хэргийн мэргэжилтэн И.Шүрээ нь 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс РТҮС УТҮГ-ын захирлын 2021 оны Б/81 дугаартай тушаалаар Архив, бичиг хэргийн эрхлэгчийн албан үүргийг түр хавсран гүйцэтгэж байна.

Зураг: Архивын өрөө, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл





Архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой илэрсэн зөрчил:

Ажилтнаас Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 23.2.1-д заасны дагуу албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн баримтыг бүрэн бүрдэлтэй хүлээн авч, хэвшсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байлаа.

Мөн "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.6, 3.7, 3.8-д тус тус заасны дагуу байгууллагын зохион байгуулалтын нэгж, ажилтнууд нь "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ын дагуу, баримтыг эмхлэн цэгцэлж, байгууллагын архивд шилжүүлсэн акт, ажилтнуудаас баримтыг нь төлөвлөгөө, хуваарийн дагуу хүлээн авсан нь баримтаар тогтоогдоогүй.

Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 2.9-д "Баримт нягтлан шалгах комисс нь жилд нэгээс доошгүй удаа 70-аас дээш хувийн ирцтэйгээр хуралдаж, асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ. Баримт нягтлан шалгах комиссын хурлыг уг хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулна" гэж заасны дагуу удирдамжийн хүрээнд 2022, 2023 онд Баримт нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг шалгахад огт

хуралдаагүй. Баримт нягтлан шалгах комиссын гишүүн ажлаас чөлөөлөгдсөн, бүтэц, орон тоо шинэчлэгдсэн байхад комисс хуралдаж, комиссыг гишүүнийг шинэчлэх ажлыг хийгээгүй.

Мөн журмын 3.5-д “Архивын ажилтан (эрхлэгч) нь хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, тоо хэмжээг үндэслэн өмнөх онд шийдвэрлэгдсэн баримт хүлээн авах хуваарийг жил бүрийн 1 дүгээр сард багтаан боловсруулж, байгууллагын даргаар батлуулна” гэж заасны дагуу Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хугацаанд нь батлуулсан боловч, 2.10.3-д “хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хянан хэлэлцэх,” гэж заасны дагуу Баримт нягтлан шалгах комисс хуралдаанаар хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хянан хэлэлцүүлээгүй, энэ талаарх хуралдааны тэмдэглэл байхгүй байна.

Батлуулсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шалгахад:

1. Зохион байгуулалтын бүтцийн нэгжид олгох хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын индекс батлуулаагүй. Тус байгууллага нь Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 7.1.6.4-д зааснаар үйл ажиллагааны цар хүрээ, орон тоо, бүтцийн хувьд цомхон, байгууллага бүтцийн нэгжид хуваагддаггүй бол индексгүй байх гэж заасан тул батлуулаагүй гэсэн тайлбар өгсөн боловч, газрын захирлын 2018 оны А/11 дүгээр тушаалаар зохион байгуулалтын нэгжид хуваагддаг болох нь тогтоогдсон байна.

2. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад зайлшгүй байх баримт бичгийн төрөл дутуу. Байгууллагын жилийн төлөвлөгөө, тайланг аль хэлтэс, албан тушаалтан гаргаж, архивд хүлээлгэн өгөх нь тодорхойгүй. Байгууллагаас тодруулахад тайлбар ирүүлээгүй.

3. 2022, 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын ирсэн, явсан бичгийн хадгалах хугацаа 5 жил байгаа нь бүртгэлийн дэвтрийн хадгалах /10ж/ хугацаанаас бага байна.

4. 2022, 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад байх “тендерийн материал”-г шалгарсан тендерийн материал гэж тайлбарласан бөгөөд энэ нь 5 жил хадгалахаар баталсан. Байнга хадгалах тендерийн материал ҮЖ 367а байнга, шалгараагүй тендерийн материал ҮЖ 367б-д зааснаар 5 жил хадгалахаар заасныг баримтлаагүй.

5. 2022 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад 2019, 2020 оны баримт оруулсан нь өмнөх оны архивын нэгжид хадгалаагүй байна.

Мөн “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 12.25.2-т “дотоодын хэрэгцээнд ашиглуулахаар олгож буй хадгаламжийн нэгж бүрийг түр олгосон баримтын бүртгэлд тэмдэглэх,” гэж заасны дагуу баримтыг судлахад журамд заасан загварын дагуу бүртгэлийг хөтлөөгүй, баримтын бүртгэлийн 2022, 2023 он холилдсон, 2023 онд хүлээн аваад 2022 онд хүлээлгэн өгсөн тэмдэглэгээтэй буюу огноо, бичиглэлийн зөрчилтэй байна.

6. Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 6.10.3-т “хадгаламжийн сангийн чийг, дулааны горимыг 7 хоногт 3-аас доошгүй удаа хэмжин, хяналт тавьж, хүснэгт 2-т заасны дагуу бүртгэл хөтлөх” гэж заасныг үйл ажиллагаандаа хэвшүүлээгүй. Журмын 6.11.4-т заасны дагуу хадгаламжийн санд цэвэрлэгээ, үйлчилгээ хийсэн тухай тэмдэглэл хөтлөөгүй байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хэвлэмэл хүүдсыг стандартын дагуу үйлдэж, эрх бүхий албан тушаалтнаар хянуулж баталгаажуулан ашиглаж буй эсэхийг шалгахад:

➤ Тус газрын захирлын 2018 оны А/11 дүгээр тушаалаар “Индекс батлах тухай” албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглах зохион байгуулалтын нэгжийн индексийг батлуулсан хэдий ч хэвлэмэл хуудсыг нэр төрлөөр нь ангилан дугаарласан индекс батлуулаагүй;

➤ Мөн тус газрын захирлын 2018 оны А/11 дүгээр тушаалын хавсралтаар баталсан нэгжийн индексийн 5-д Хангамж, үйлчилгээний алба 04-1 дугаар хэрэглэхээр

заасан. Гэвч Хангамж, үйлчилгээний албаны дарга 2023 онд 01/08 дугаараар “Петровис” ХХК-д албан бичиг илгээсэн байна. Тодруулбал албан бичгийн 04-1/08 гэж дугаарлаагүй буюу тушаалаар зөвшөөрөгдөөгүй индекс хэрэглэсэн байна;

➤ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 40, 41, 42, 43 дугаар зүйлд заасан ирсэн, явуулсан баримт бичгийг төвлөрсөн байдлаар бүртгэж хэвшсэн эсэхийг шалгахад бүртгэлийн дэвтэрт хөтөлж, дардсаар тэмдэглээ тэмдэглэдэг боловч, ирсэн, явсан бичгийн баталгааны дардас нь Монгол Улсын стандарт (MNS 5140-2:2021)-ын 5.20, 5.23-д заасан стандартад нийцээгүй байна;

➤ Албан хэрэг хөтлөлтийн программ ашиглаж буй тохиолдолд баримт бичиг болон холбогдох баримтыг мэдээллийн санд бүрэн оруулдаг эсэхэд ажлын ачаалал, хүний нөөцийн дутмаг байдлаас шалтгаалан захирлын туслах Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (<https://erp.e-mongolia.mn/>)-д ирсэн цахим бичгийг хүлээн авч бүртгэж байна.

Системийг тус байгууллага нь 2021 оноос ашиглаж эхэлсэн бөгөөд хүний нөөц, удирдлага, үүрэг даалгавар, цаг бүртгэл, олон нийтийн арга хэмжээ, файлын сан, судалгаа, утасны жагсаалт ашигладаг байна. Харин цаасан суурьтай албан бичгийг системд бүртгэдэггүй, шийдвэрлэх хугацааг бичиж хяналт тавьдаггүй, хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл системд харагддаггүй, цахим системийн боловсруулалт ашиглаж эхлээгүй байгаа нь цахим архив үүсгэх, цахим системийг бүрэн ашиглаж хэрэглээнд нэвтрүүлээгүй байна. Мөн цаасан суурьтай баримт бичигт бүртгэл хяналтын карт хөтөлдөг боловч, бүртгэл хяналтын картад хэрхэн, хэн, хэзээ шийдвэрлэсэн нь тодорхойгүй байна;

➤ Захирамжлалын болон зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичгийг оны эхнээс нэгдсэн дугаар өгч бүртгэдэг боловч журамд заасны дагуу хэвлэмэл хуудасны индексийг зөв дугаарладаггүй;

➤ Баримт бичгийн төслийг стандартын дагуу зохиож, бүрдүүлсэн эсэхэд байгууллагын болон холбогдох бүтцийн нэгжийн удирдлага хяналт тавьж буй эсэх, хугацаандаа шийдвэрлэдэг эсэхийг тодруулах боломжгүй, төслөө хадгалдаггүй;

➤ Захирамжлалын баримт бичгийн бүрдлийг Монгол Улсын стандарт /MNS5140-2:2021/-ын дагуу бүрэн хангасан эсэхийг нягтлан шалгахад дээрх стандартын 5.15-д заасны дагуу хавсралт баримт бичгийг дугаарлаагүй, хавсралтын тэмдэглэгээ хийгээгүй, тоон дүнг 3 өөр байдлаар алдаатай бичсэн;

➤ Захирамжлалын болон зохион байгуулалтын баримт бичигт бичвэрийн мөр, зай стандарт бус, үг үсгийн алдаатай, дугуй хаалт хэрэглээгүй, харилцагчийн нэр хязгаарлах тэмдгээс хэтэрсэн, хариу огноо, дугаар бичигдээгүй, хэвлэмэл хуудасны индекс зөв хэрэглэж хэвшээгүй;

➤ Баримт бичгийн хавсралтын тухай тэмдэглэгээг үйлдэж, хавсралтыг бүрэн хавсаргасан эсэхийг нягталж үзэхэд хавсралт бүрэн боловч, хавсралтын тэмдэглэлийг стандартын 5.15, 5.19-д заасан шаардлагыг бүрэн хангаагүй.

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /Зөвлөмж/

“Радио, телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын салбарын бодлого, төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын ажлыг үндэслэн дүгнэлт гаргаж, чиглэл тус бүрд дараах зөвлөмжийг хүргүүлж байна:

1.Бодлогын чиглэлээр:

1. Орон нутгийн дамжуулах станцуудад нөөц төхөөрөмжтэй байлгах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

2. Гэмтэл саатлын мэдээг гаргахдаа бүртгэл, засварлалт, нөөц тоног төхөөрөмжийн мэдээллийг бүрэн оруулж, дүн шинжилгээ хийх боломжтой программ хангамж ашиглах;

3. Жил бүр төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, гарч болзошгүй гэмтэл саатлыг тодорхойлж, шаардлагатай засвар үйлчилгээг хийж хэвших;

4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д “хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэж заасны дагуу Засгийн газраар тус газрын дүрмийг батлуулах арга хэмжээ авах;

5. Холболт, дамжуулалтын гэрээг бүх байгууллага /NTV телевиз, Star телевиз, SBN телевиз, ТМ телевиз, С1 телевиз, TV-8 телевиз, UBS телевиз, Сүлд телевиз/ 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөрт багтаан байгуулж дуусгах. Мөн МҮОНРТ-тэй байгуулсан ТГ 18/54 тоот гэрээний хугацаа 2020 оны 04 дүгээр сард дууссан бөгөөд дахин сунгалт хийгдээгүй тул гэрээг дахин шинэчлэх;

6. Үйлчилгээ тус бүрд үнэ тариф болон жишиг гэрээний загварыг ил тод байршуулах;

7. Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн чанарын менежментийн тогтолцоо болон бусад стандартуудыг нэвтрүүлэх;

8. Телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээг гэрээт байгууллагатай хамтран үйлчилгээний стандартад нийцүүлэн дахин тохируулга хийх.

2. Хүний нөөцийн чиглэлээр 2022-2023 онд гаргасан захирлын тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл, боловсруулалтын хүрээнд:

1. Үйл ажиллагааны болон хүний нөөцийн чиглэлээр гарч байгаа тушаал шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад журмын оновчтой зохицуулалтыг үндэслэх;

2. Тушаалын үндэслэх хэсэгт эрх олгосон хууль, дүрэм, журам гэсэн эрх зүйн ач холбогдлын дарааллаар тушаалыг боловсруулах;

3. Захирамжлалын баримт бичгийн стандартын дагуу Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, журмыг мөрдлөг болгон утга агуулга, хэлбэрийн, үг үсгийн алдаагүй тушаал шийдвэр гаргах; /Тушаалын дугаарыг гаргагдахуйц тод, цэвэр бичих; тушаалд дугаар, дүгээр гэсэн үгийг ашиглах, тушаалын хэвлэмэл хуудасны индексийг тод дарах/

4. Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчмыг хэрэгжүүлэх аргачлал”, 06 дугаар тогтоолоор баталсан “Цалин хөлс тогтоох аргачлал”-ыг тус тус баримтлан цалингийн сүлжээг батлах;

5. Баримт бичигт үндэслэх хуулийн зүйл, хэсэг, заалтыг зөв бичих /Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь хэсэгт гэж бичих/;

6. Хууль хэрэглээний болон бусад зөрчилтэй тушаал, шийдвэрийн зөрчлийг арилгах;

3. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар:

1. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдол шийдвэрлэх тухай хуулийн дагуу өргөдөл гомдлыг хүлээн авч, хууль зүйн үндэслэлтэй, хуулийн хугацаанд холбогдох ажиллагааг хийж шийдвэрлэж, хариу мэдэгдэх;

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт Төрийн байгууллага, албан тушаалтан хуульд заасан чиг үүргийнхээ

хүрээнд цахим хэлбэрээр харилцахдаа албаны цахим шуудан болон энэ хуулийн 21, 23, 24 дүгээр зүйлд заасан дэмжих системийг ашиглана гэж заасны дагуу албан хариуг хүргүүлэхдээ албаны цахим шуудан эсвэл дэмжих систем ашиглах;

3. Өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэрт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг тодорхой бичиж, бүрэн хөтлөх;

4. 2022 онд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хүрээнд:

1. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас өгсөн зөвлөмжийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэн, шийдвэрлэлтийн талаар эргэж албан ёсоор мэдээлдэг байх;

2. Хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг 2022 онд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар хүргүүлсэн бичгийн шийдвэрлэлтийг шалгахад голлох 12 зөвлөмжийн биелэлтийн дундаж 75.8 хувьтай байх тул 2022 онд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах, хэрэгжилтийн мэдээллийг яаманд 2023 онд хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийн хамтаар эргэн мэдээлэх;

5. Архив, албан хэрэг хөтлөлтийн хүрээнд:

1. Архив, албан хэрэг хөтлөлтийг хууль, журам, стандартад нийцүүлэн хэвшүүлэх;

2. Архив, бичиг хэргийн эрхлэгчийг үндсэн ажилтнаар ажиллуулах;

3. Архив, бичиг хэргийн эрхлэгчийг сургаж, мэргэшүүлэх;

4. Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системийг байгууллагад бүрэн нэвтрүүлж, холбогдох газраас сургалт авч, хэвшүүлэх.

5. Байгууллагын баримт бичгийг боловсруулахад Монгол улсад мөрдөгдөж буй Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам, 2016 оны Архивын ерөнхий газрын даргын нэмэлт өөрчлөлт оруулсан Байгууллагын архивын ажлын үндсэн заавар, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Стандарт хэмжил зүйн газрын Баримт бичгийн стандартын эмхэтгэл MNS5140-1:2021, MNS5140-2:2021, MNS5140-3:2021 зэрэг эрх зүйн баримт бичгийг мөрдлөг болгон ажиллах;